МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ

# Гадаадад зорчих Гарын авлага

# consul.mn




- Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газартай холбоо барих мэдээлэл
- Гадаадад зорчиход анхаарах зүйлс
- “Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан”- гаас хэрхэн санхүүгийн тусламж авах
- Визгүй зорчих орнуудын албан ёсны жагсаалт
- Консулын холбогдолтой эрх зүйн баримт бичиг
- Монгол Улсад суугаа гадаадын дипломат төлөөлөгчийн газрын мэдээлэл
- Улаанбаатар дахь гадаад улсын виз мэдүүлгийн төв
- Консулын баталгаа буюу Апостиль гэрчилгээ хэрхэн авах тухай

**2022 он**

МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ

# МОНГОЛ УЛСЫН КОНСУЛ

*Дипломат албаны бүрэлдэхүүн хэсэг*

*Хилийн чанадад Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үндсэн үүрэгтэй.*

## КОНСУЛ ГЭЖ ХЭН БЭ?

Та гадаадын улс орнуудад зорчих, оршин суух хугацаанд таны эрх ашгийг хамгаалах, таны төлөө боломжтой бүхий л арга хэмжээг авч, төрийн үйлчилгээг хүргэдэг хүнийг "Консул" гэнэ.

consul.mn




| Улс | Иргэдийн тоо |
|---|---|
| БНСУ | 37,000 |
| АНУ | 30,000 |
| Япон | 13,500 |
| Чех | 10,946 |
| Швед | 10,538 |
| Франц | 7,000 |
| Герман | 6,420 |
| Турк | 6,000 |
| Австрали | 5,800 |
| Казахстан | 5,078 |
| ИБУИНВУ | 4,000 |
| Швейцарь | 3,840 |
| Унгар | 3,590 |
| ОХУ | 3,000 |
| Австри | 2,578 |
| БНХАУ +33ОБ | 1,986 |

МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ

# КОНСУЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ ГЭЖ ЮУ ВЭ?

## ТА ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ КОНСУЛЫН ГАЗАРТ ХАНДСАНААР ДАРААХ ҮЙЛЧИЛГЭЭГ АВАХ БОЛОМЖТОЙ:

- Гадаад улсад хэрэглэгдэх бичиг баримтыг баталгаажуулах
- Таны гадаадад зөрчигдсөн эрх ашгийг хамгаалах, туслалцаа үзүүлэх
- Дипломат, албан, бизнесийн шугамаар Монголд ирэх гадаадын иргэнд визийн зөвшөөрөл авах.

## ГАДААДАД БАЙГАА МОНГОЛ УЛСЫН ЭЛЧИН САЙДЫН ЯАМ, КОНСУЛЫН ГАЗАР:

- Таны гадаадад зөрчигдсөн эрх ашгийг хамгаалах, туслалцаа үзүүлэх
- Гэрлэлтийн гэрчилгээ олгох
- Төрсний гэрчилгээ, гадаад паспорт олгох
- Эрх зүйн зөвлөгөө өгөх
- Иргэний бүртгэлийн бусад үйлчилгээ үзүүлэх
- Нотариатын үйлчилгээ үзүүлэх
- Монголд ирэх гадаадын иргэнд виз олгох



## Консулын үйл ажиллагаа, чиг үүрэгтэй холбоотой зайлшгүй мэдэх зүйлс:

- Гадаад харилцааны яам, Дипломат төлөөлөгчийн газрын консулын үйл ажиллагаа нь тухайн улсын хууль тогтоомжийн хүрээнд өөрийн улсын иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалахад чиглэгддэг.
- Консул нь гадаад улсын виз олгуулах, виз мэдүүлэх цаг авч өгөх, Элчин сайдын яам, Консулыг нь шахаж шаардах, шийдвэр гаргахад нөлөөлөх боломжгүй. Учир нь аливаа улсын Элчин сайдын яамны виз олгох үйл ажиллагаа, виз олгох эсэх шийдвэр гаргах нь тухайн улсын хууль тогтоомжийн хүрээнд шийдэгддэг.
- Аль нэг улсын визийн хугацаа хэтрүүлсэн, тухайн улсын хилээр нэвтрэх журмыг зөрчсөн, хилийн хориг тавигдсан бол цуцлуулах, хугацааг нь богиносгох боломжгүй. Энэ тохиолдолд тухайн улсын хууль тогтоомжийн дагуу иргэн өөрөө давж заалдах бөгөөд хилийн хориг нь дуустал зорчих эрхийг сэргээх боломж хомс байдаг.
- Гэмт хэрэг, зөрчилд холбогдсон иргэний гэм буруутай эсэхийг тогтоох, мөрдөн шалгах, суллуулах, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх, гадаад улсын шүүхийн үйл ажиллагаа, шүүхийн шийдвэрт нөлөөлөх боломжгүй.
- Хууль, журамд нийцээгүй, илт хууль бус хүсэлтийг шийдвэрлэх үүрэггүй болно.

МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ

# ӨРГӨМЖИТ КОНСУЛ

Гадаад харилцааны яамнаас гадаад улсад Өргөмжит консул томилж, консулын зарим үүргийг гүйцэтгүүлдэг.

Өргөмжит консул нь тухайн улсын иргэн эсвэл Монгол Улсын иргэн байж болдог.

Өргөмжит консул нь тухайн улстай худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжүүлэх, аялал жуулчлал, хөрөнгө оруулалтыг татахад дэмжлэг үзүүлэн ажилладаг.

**Монгол Улсын**
**60**
**Өргөмжит консул гадаадын 44 оронд томилогдон ажиллаж байна.**

**Монгол Улсад гадаадын**
**40**
**орны Өргөмжит консул байна**

***Өргөмжит консул нь гадаадад байгаа монгол иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалахад зөвлөгөө өгөх, зохих туслалцаа үзүүлэх үүрэгтэй боловч иргэний бүртгэл, нотариатын үйлчилгээ үзүүлэх боломжгүйг анхаарна уу.***

consul.mn

/mfamongoliaMN/

@MongolDiplomacy

mfa.gov.mn

consul.mn

МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ

# ИРГЭДЭД ТУСЛАХ САН

## Монгол Улсын иргэн дараах тохиолдолд Иргэдэд туслах сангаас санхүүгийн тусламж авах эрхтэй:

- Хилийн чанадад нас барсан иргэний гэр бүл нь түүний шарилыг эх оронд нь буцаах зардалгүй, эсхүл гэр бүл, төрөл садан нь тогтоогдоогүй тохиолдолд түүний шарилыг хадгалах, чандарлах, шарил болон чандрыг эх оронд нь буцаах буюу тухайн улсад нь нутаглуулах;

- Гэмт хэргийн улмаас хохирсон буюу эд хөрөнгөө хаяж гээгдүүлсний улмаас төлбөрийн чадваргүй болсон иргэнийг эх оронд нь буцаах;

- Дээр дурдсан иргэний гадаад паспортын хугацааг сунгах, буцах үнэмлэх олгох, эх оронд нь буцаахтай холбогдсон бусад үйлчилгээ үзүүлэх;

- Хилийн чанадад байгалийн онц аюултай гамшиг, алан хядах ажиллагаа, зэвсэгт мөргөлдөөнд өртсөн, эсхүл осол, гэмт хэргийн улмаас хүнд гэмтэл авсан, сэтгэцийн өвчтэй болсон, амь насанд нь аюул учирсан иргэнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эх оронд нь буцаах;

- Хилийн чанадад хорих ял эдэлж байгаад, эсхүл албадан саатуулагдаж байгаад суллагдсан иргэнийг эх оронд нь буцаах;

- Хилийн чанадад гэмт хэргийн улмаас хохирсон иргэнтэй холбоотой асуудлыг тухайн улсын холбогдох хууль хяналтын байгууллагаар хянуулах, эрх ашгийг нь хамгаалахад шаардагдах өмгөөлөгч, орчуулагчийг хөлслөх;

- Хилийн чанадад хорих ял эдэлж байгаа иргэнийг Элчин сайдын яам, Консулын газрын ажилтан эргэх;

МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ

# ГАДААДАД АЯЛАХЫН ӨМНӨ АНХААРВАЛ ЗОХИХ 10 ЗҮЙЛС

- Зорчих гэж буй улс орныхоо талаар хамгийн сүүлийн үеийн мэдээ, мэдээлэл олж авах, судлах.

- Өөрийн гадаад паспортын хүчинтэй хугацааг сайтар шалгах. Таны паспортын дуусах хугацаа 6 сараас илүү байх ёстой.

- Очих гэж буй улсад манай улсын иргэд визтэй зорчдог бол та урьдчилан виз авсан байх. Өөр улс орноор дамжин өнгөрөх тохиолдолд тухайн орны хил, гааль, визийн журмыг сайтар судалсан байх.

- Даатгал хийлгэхдээ өөрийн аялалтай холбогдсон заалтууд хамаарагдаж буй эсэхийг нягтлан шалгах.

- Явах маршрут, тээврийн хэрэгслээ /онгоц, галт тэрэг, усан онгоц гэх мэт/ зөв сонгож, зорчих билет, тасалбараа авсан эсэхээ шалгах.

- Ямар ч нөхцөлд өөрийн гадаад паспорт, зорчигчийн тасалбар, кредит карт, чекийг биедээ авч явах хэрэгтэй. Харин хуулбар хувийг гар тээшинд хадгалахаас гадна гэр бүлийнхээ аль нэг гишүүнд давхар хадгалуулах.

- Гадаадад явахын өмнө өөрийн эрүүл мэндийг сайн нягтлах. Зарим оронд вакцин хийлгэхийг шаарддагийг анхаарах. Зөвшөөрлийн гарал үүслийн бичиггүй эм, тариаг авч явахгүй байх. Учир нь танаас асуухгүйгээр тээшнээс шууд хураан авдаг журамтай.

- Өөрийн гэр бүлийн гишүүд, найз нөхөд дөө явах гэж буй зорилго, маршрут, цаг хугацаагаа тайлбарлаж, очих газрын хаяг, зочид буудал, холбоо барих хэрэгслүүдийн талаарх мэдээллийг өгсөн байх.

- Өөрийн авч явах эд зүйлүүдээс гадна таних, танихгүй хүмүүсээс элдэв дайвар ачаа авч явахаас зайлсхийх, ачаа барааныхаа баглаа, битүүмжлэлд онцгой анхаарах.

- Аюулгүй байдлын үүднээс өөрийн хувийн мэдээлэлдээ анхаарч бэлтгэлээ хангах.

МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ

# ХИЛ, ГААЛИАР НЭВТРЭХ ҮЕД МӨРДӨХ ЗҮЙЛС

Та насанд хүрээгүй өөрийн болон өөр хүний хүүхэд авч явах гэж байгаа бол зохих журам, хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагаас бичиг, баримтыг нь бүрдүүлж авч явах ёстой.

Тухайлбал, ах, дүү, төрөл, төрөгсөд, найз нөхөд, танилынхаа насанд хүрээгүй хүүхдийг авч явах тохиолдолд тэдний эцэг, эх, асран хамгаалагчийн итгэмжлэлийг англи, эсхүл очих улсын хэл дээр орчуулж нотариатаар баталгаажуулан, мөн Гадаад харилцааны яамны Консулын газраар давхар баталгаажуулалт хийлгэсэн байна. Итгэмжлэл, зохих зөвшөөрөлгүй тохиолдолд таныг хилээр нэвтрүүлэхгүйгээс гадна хүн худалдаалах гэмт хэрэгт сэжиглэж болзошгүйг анхаарах хэрэгтэй.

- Тэсэрч, дэлбэрэх зүйлс, буу, сум
- Мансууруулах төрлийн бодисууд, хар тамхи
- Уусамтгай, идэмхий бодисууд /хүчил/
- Тухайн орны хил, гаалийн хуульд заасан хэмжээнээс хэтэрсэн их хэмжээний бэлэн мөнгө, хоол, мах ...

*Хилээр авч орохыг зөвшөөрсөн мөнгөний хэмжээ, хориглосон зүйлийн тухай мэдээлэл ихэнх улсын хил гаалийн байгууллагын вэб сайтад байдаг тул явахаасаа өмнө интернетээс харах хэрэгтэй.*

consul.mn

Дэлгэрэнгүй мэдээллийг
**www.consul.mn**

МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ

# ХИЛИЙН ЧАНАДАД БАЙХ ҮЕДЭЭ АНХААРАХ ЗҮЙЛС

- Согтууруулах ундааны зүйлс хэтрүүлэн хэрэглэхээс зайлсхийх, бусадтай муудалцахаас зайлсхийх,

- Өөрийн амьдарч буй байр, орон сууц, зочид буудалдаа хүний дайвар, захиас, ачаа барааг сайтар үзэж шалгахгүйгээр хадгалах, бусдад дамжуулах зорилгоор авах зэрэгт хянуур хандах,

- Телефон утас, интернет болон холбоо мэдээллийн хэрэгслээр ажил төрлөөсөө өөр тухайн улсын улс төр, нийгэм, цаг үеийн нөхцөл байдлын талаар аль болох ярихгүй байхыг эрхэмлэх,

- Паспорт, бичиг баримтаа барьцаанд тавихгүй байх, бусдад өгөхгүй байх,

- Казино, мөрийтэй тоглоом, биеэ үнэлэгчдээс зайлсхийх,

- Бусдын найр тавьсан саналд болгоомжтой хандах, шинэ танилаас болгоомжлох,

- Гадаадын иргэд зорчихыг хориглосон болон жагсаал, цуглаан болж буй газар очихгүй байх,

- Хууль бус хөдөлмөр эрхлэх, виз хэтрүүлэхгүй байх.

consul.mn

Дэлгэрэнгүй мэдээллийг

**www.consul.mn**

МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ

# ХИЛИЙН ЧАНАДАД БАЙХ ҮЕДЭЭ АНХААРАХ ЗҮЙЛС

Сүм хийд, мөргөлийн газарт ёс журамтай, хүндэтгэлтэй хандах.

Тухайн улс оронд соёл, ёс, заншил, жишигт нь нийцүүлэн хувцаслах. Ялангуяа исламын хатуу ёс заншилтай орнуудад ёс жаягт нь харшлах хувцас өмсөхгүй байх.

Фото зураг авах, видео бичлэг хийхийн өмнө зөвшөөрөл заавал асууж байх.

Төр засгийн ордон, музей, цэрэг армийн зориулалт бүхий барилга байгууламжийн зураг авах, бичлэг хийхийг зарим улсад хориглосон байдгийг анхаарах.

Гудамж талбай, олон нийтийн газарт тэврэлдэх, бохь зажлах зэрэг үйлдлийг зөвшөөрдөггүй улс, үндэстэн байдгийг бодолцох зэрэг болно.

Хэрэв та хилийн чанадад зорчиж явахдаа паспорт, бичиг баримтаа үрэгдүүлэх, хулгайд алдсан тохиолдолд тухайн улсын цагдаагийн байгууллагад тэмдэглүүлж, ойр байрлах ЭСЯ-тай яаралтай холбогдож мэдэгдэн, буцах үнэмлэх авах шаардлагатай.

Хилийн чанадаас эх орондоо эргэж ирэхдээ хил, гаалийн хууль тогтоомжоор зөвшөөрөөгүй эд зүйл, ачаа тээшинд чинь байгаа эсэхийг нягтлан хориотой ургамал, эм тан, ангийн үс арьс, өвчин үүсгэгч зүйл гэх мэт.

Гадаадад байхдаа тухайн улс орон, ард түмний ёс заншлыг хүндэтгэж, "Усыг нь уувал ёсыг нь дагаж" явах нь чухал.

consul.mn

Дэлгэрэнгүй мэдээллийг

**consul.mn**

ХАР ТАМХИ, МАНСУУРУУЛАХ ТӨРЛИЙН БОДИСТОЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

ХҮНИЙ НАЙМААНЫ ЗОЛИОС БОЛОХООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

**СҮҮЛИЙН ҮЕД ДЭЛХИЙ НИЙТИЙН АНХААРЛЫГ ТАТСАН ГЭМТ ХЭРГИЙН ТООНД ХАР ТАМХИ, МАНСУУРУУЛАХ ТӨРЛИЙН БОДИСТОЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ХЭРЭГ ЗҮЙ ЁСООР ОРЖ БАЙНА.**
Энэ төрлийн гэмт хэрэг нь ихэвчлэн зохион байгуулалттай, олон хүнийг хамарсан, нууц хэлбэрээр үйлдэгддэг. Ихэнх улс орны хууль тогтоомжоор хар тамхитай холбоотой гэмт хэрэг үйлдэгсдэд ноогдуулах ялын хэмжээ өндөр байдаг. Тухайлбал, БНХАУ-ын Эрүүгийн хуульд зааснаар 50 граммаас дээш хэмжээний хар тамхи, мансууруулах төрлийн бодис авч явсан, тээвэрлэсэн /биедээ авч явах/, хадгалсан, худалдсан, хууль бусаар хил нэвтрүүлсэн тохиолдолд 15 жилийн хорих ял оноохоос эхлээд бүх насаар нь хорих, цаазаар авах ял шийтгэдэг хуулийн заалттай болно.

**ХЭН НЭГЭН ХҮН ТАНД ЭСХҮЛ ТАНЫ ОЙР ДОТНЫ НАЙЗ НӨХДӨД ДАРААХ САНАЛЫГ ТАВЬСАН БОЛ:**
Гадаадад өндөр цалин, хөлстэй ажил хийх !
Гадаадын иргэнтэй зуучлалаар гэрлэх !
Гадаадад очоод цалингаасаа зуучлалын хөлсөө төлөх!
Замын зардлыг чинь даах зэрэг !

Ийм төрлийн залилан мэхлэх гэмт хэргийн хохирогч болохоос зайлсхийх, энэ төрлийн зар тарааж буй этгээдийн талаарх мэдээллийг цагдаагийн байгууллагад мэдэгдэж байхыг Гадаад харилцааны яамны Консулын газраас анхааруулж байна.

Гадаад харилцааны яамны Консулын газрын www.consul.mn хуудсанд хандан, тухайн улсад суугаа ДТГ-т хандах боломжтой.

consul.mn

Дэлгэрэнгүй мэдээллийг:

**consul.mn**

МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ

# Дипломат болон албан ангиллын виз

Гадаад харилцааны яамны Консулын газар нь Монгол Улсад 30-аас доош хоногоор ирэх гадаадын иргэнд дараах ангиллын визийн зөвшөөрлийг олгоно.




## 'D', 'A1', 'A2' буюу дипломат болон албан ангиллын виз

- Монгол Улсын олон улсын гэрээгээр визгүй зорчих орнуудын иргэдийн хувьд зөвшөөрөл шаардлагагүй.

- Монгол Улсад аялал жуулчлалаар ирэх гадаадын иргэнд ямар нэг урилга шаардлагагүй байдаг.

*Дээрхээс бусад ангиллын виз болон Монгол Улсад оршин суух зөвшөөрлийг Гадаадын иргэн, харьяатын газар хариуцна.*

*Холбоо барих утас: 1800-1882*
*Цахим хуудас: www.immigration.gov.mn*

consul.mn

Дэлгэрэнгүй мэдээллийг

**www.consul.mn**

МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ

# АПОСТИЛЬ ГЭРЧИЛГЭЭ, КОНСУЛЫН БАТАЛГАА

Монгол Улсын бичиг баримтыг гадаадын улс орнуудад хэрэглэх тохиолдолд апостиль гэрчилгээгээр баталгаажуулах шаардлагатай. Ингэснээр ямар нэг дахин баталгаажуулалт шаардахгүйгээр таны бичиг баримт Апостиль конвенцийн гишүүн **122**улсад хүчин төгөлдөр болох юм.

## КОНСУЛЫН ГАЗАРТ ХАНДАН ДАРААХ ТӨРЛИЙН БИЧИГ БАРИМТАД АПОСТИЛЬ ГЭРЧИГЭЭ АВАХ БОЛОМЖТОЙ:

- Иргэний үнэмлэх, паспорт, төрсний болон гэрлэлтийн гэрчилгээ зэрэг бүх төрлийн иргэний бүртгэлийн гэрчилгээ,
- Иргэний бүртгэлийн болон цагдаагийн тодорхойлолт
- Бүх шатны боловсролын гэрчилгээ
- Шүүх, прокурорын шийдвэр
- Төрийн захиргааны байгууллагаас олгодог бусад баримт бичиг

## АПОСТИЛЬ ГЭРЧИЛГЭЭ АВАХАД ДАРААХ МАТЕРИАЛЫГ БҮРДҮҮЛНЭ:

- Апостиль гэрчилгээ авахдаа тухайн баримт бичгийн хуулбарыг орчуулгын хамт нотариатаар баталгаажуулсан байна.
- Апостиль гэрчилгээний хураамжийг банкинд тушаасан төлбөрийн баримт
- Апостиль гэрчилгээ авах өргөдлийн маягтыг Гадаад харилцааны яамны Консулын газрын www.consul.mn цахим хуудаснаас татан авах боломжтой.


APOSTILLE

| | |
|---|---|
| 1. Country: | Mongolia |
| This public document | |
| 2. has been signed by | O.C |
| 3. acting in the capacity of | Notary |
| 4. bears the seal /stamp of | Ulaanbaatar |
| Certified | |
| 5. at Ulaanbaatar, Mongolia | 6. the 22 August, 2019 |
| 7. by | , Deputy Director |
| 8. № | 2019 |
| 9. Seal / stamp Consular Department | 10. Signature: |

*** Апостиль гэрчилгээг зөвшөөрдөггүй улсад хэрэглэх бичиг баримтад Консулын газар консулын баталгаа хийнэ.**

Апостиль гэрчилгээг зөвшөөрдөг орнуудын жагсаалтыг

**www.consul.mn**

МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ

# “ХАРИУЦЛАГАТАЙ АЯЛЦГААЯ”



Монгол Улс,
Бүгд Найрамдах Солонгос Улс
болон Америкийн Нэгдсэн Улс
хууль ёсны аяллыг дэмжих
нийтлэг зорилгоор нэгдэж байна.

#TravelResponsibly
책임과 신뢰가 함께하는 여행

*Илүү нээлттэй
ирээдүйд хүрэх гүүр
танаас эхлэлтэй.*

#TravelResponsibly

Report fraud to: UlaanbaatarFPU@state.gov

travel.state.gov www.consul.mn mng.mofa.go.kr

МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ
Консулын газар

МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ

# МОНГОЛ УЛСЫН ИРГЭД ВИЗГҮЙ ЗОРЧИХ ОРНУУД

| № | Улс орон | Зорчих нөхцөл, визгүй зорчих хугацаа, Хүчин төгөлдөр болсон огноо |
|---|---|---|
| 1. | Хятад | Бүх төрлийн паспортаар **30** хоног хүртэл / 1989.03.30 |
| 2. | Филиппин | Бүх төрлийн паспортаар **21** хоног хүртэл / 1994.05.13 |
| 3. | Малайз | Бүх төрлийн паспортаар **30** хоног хүртэл / 1994.06.06 |
| 4. | Казахстан | Бүх төрлийн паспортаар **90** хоног хүртэл / 1994.12.02 |
| 5. | Израйль | Бүх төрлийн паспортаар **30** хоног хүртэл / 1996.03.12 |
| 6. | Хонконг /БНХАУ/ | Бүх төрлийн паспортаар **14** хоног хүртэл / 1998.06.18 |
| 7. | Киргиз | Бүх төрлийн паспортаар **90** хоног хүртэл / 1999.12.04 |
| 8. | Куба | Бүх төрлийн паспортаар **30** хоног хүртэл / 2001.10.08 |
| 9. | Макао /БНХАУ/ | Бүх төрлийн паспортаар **90** хоног хүртэл / 2004.07.03 |
| 10. | Лаос | Бүх төрлийн паспортаар **30** хоног хүртэл / 2007.10.14 |
| 11. | Тайланд | Бүх төрлийн паспортаар **30** хоног хүртэл / 2008.01.13 |
| 12. | Беларусь | Бүх төрлийн паспортаар **90** хоног хүртэл / 2013.09.04 |
| 13. | Турк | Бүх төрлийн паспортаар **30** хоног хүртэл / 2013.10.10 |
| 14. | Серби | Бүх төрлийн паспортаар **90** хоног хүртэл / 2013.11.08 |
| 15. | ОХУ | Бүх төрлийн паспортаар **30** хоног хүртэл / 2014.09.03 |
| 16. | Бразил | Бүх төрлийн паспортаар **90** хоног хүртэл / 2015.09.21 |
| 17. | Сингапур | Бүх төрлийн паспортаар **30** хоног хүртэл / 2017.06.08 |
| 18. | Украин* | /Албан ёсны урилгатай / Бүх төрлийн паспортаар **90** хоног хүртэл |
| 19. | Аргентин | Бүх төрлийн паспортаар **90** хоног хүртэл / 2018.02.19 |
| 20. | Уругвай | Бүх төрлийн паспортаар **30** хоног хүртэл / 2018.06.10 |
| 21. | Чили | Бүх төрлийн паспортаар **90** хоног хүртэл / 2018.12.29 |
| 22. | Эквадор | Бүх төрлийн паспортаар **90** хоног хүртэл / 2020.10.23 |
| 23. | Перу | Бүх төрлийн паспортаар **90** хоног хүртэл / 2021.10.01 |
| 24. | Узбекистан | Бүх төрлийн паспортаар **30** хоног хүртэл / 2022.06.03 |
| | | **ДИПЛОМАТ, АЛБАН ПАСПОРТ** |
| 25. | Румын | Дипломат, албан паспортаар **30** хоног хүртэл / 1974.10.14 |
| 26. | БНАСАУ | Дипломат, албан паспортаар **90** хоног хүртэл / 1986.11.14 |
| 27. | Словак | Дипломат, албан паспортаар **90** хоног хүртэл / 1992.06.26 |
| 28. | Чех | Дипломат паспортаар **90** хоног хүртэл / 1992.06.26, 2011.07.29 |
| 29. | Вьетнам | Дипломат, албан паспортаар **90** хоног хүртэл / 2000.01.07 |
| 30. | Мексик | Дипломат, албан паспортаар **90** хоног хүртэл / 2001.11.09 |
| 31. | Энэтхэг | Дипломат, албан паспортаар **90** хоног хүртэл / 2005.12.23 |
| 32. | Болгар | Дипломат, албан паспортаар **90** хоног хүртэл / 2011.01.18 |
| 33. | Кипр | Дипломат, албан паспортаар **90** хоног хүртэл / 2011.03.30 |
| 34. | Польш | Дипломат, албан паспортаар **90** хоног хүртэл / 2011.06.29 |
| 35. | БНСУ | Дипломат, албан паспортаар **90** хоног хүртэл / 2012.05.31 |
| 36. | Камбож | Дипломат, албан паспортаар **30** хоног хүртэл / 2012.08.27 |

# МОНГОЛ УЛСЫН ИРГЭД ВИЗГҮЙ ЗОРЧИХ ОРНУУД

| | | |
|---|---|---|
| 37. | Кувейт | Дипломат, албан паспортаар **90** хоног хүртэл / 2013.04.16 |
| 38. | Перу | Дипломат, албан паспортаар **90** хоног хүртэл / 2013.04.30 |
| 39. | ХБНГУ | Зөвхөн Цахим дипломат паспортаар **90** хоног хүртэл / 2013.05.08 |
| 40. | Бруней | Дипломат, албан паспортаар **14** хоног хүртэл / 2013.07.01 |
| 41. | Колумб | Дипломат, албан паспортаар **30** хоног хүртэл / 2013.09.23 |
| 42. | Франц | Дипломат паспортаараар **90** хоног хүртэл / 2013.10.26 |
| 43. | Мьянмар | Дипломат, албан паспортаар **30** хоног хүртэл / 2013.11.18 |
| 44. | Эстони | Зөвхөн Цахим дипломат паспортаар **90** хоног хүртэл / 2014.04.28 |
| 45. | Латви | Дипломат, албан паспортаар **90** хоног хүртэл / 2014.06.12 |
| 46. | Итали | Дипломат паспортаар **90** хоног хүртэл / 2014.07.14 |
| 47. | Туркменистан | Дипломат, албан паспортаар **30** хоног хүртэл / 2015.06.03 |
| 48. | Унгар | Дипломат, албан паспортаар **90** хоног хүртэл / 2016.05.18 |
| 49. | Япон | Дипломат паспортаар **30** хоног хүртэл / 2016.11.15 |
| 50. | Балба | Дипломат, албан паспортаар **90** хоног хүртэл / 2016.12.1, 2017.01.18 |
| 51. | Албани | Цахим дипломат, цахим албан паспорт **90** хоног хүртэл / 2017.03.30 |
| 52. | Хорват | Дипломат, албан паспортаар **30** хоног хүртэл / 2017.04.26 |
| 53. | Мальта | Дипломат, албан паспортаар **30** хоног хүртэл / 2018.02.08 |
| 54. | Литва | Дипломат, албан паспортаар **30** хоног хүртэл / 2018.04.29 |
| 55. | Швейцарь | Дипломат, албан паспортаар **90** хоног хүртэл / 2018.06.16 |
| 56. | Азербайжан | Дипломат, албан паспортаар **90** хоног хүртэл / 2019.02.07 |
| 57. | Армян | Дипломат, албан паспортаар **30** хоног хүртэл / 2019.06.02 |
| 58. | Грек | Дипломат, албан паспортаар **90** хоног хүртэл / 2020.05.10 |
| 59. | Словени | Дипломат, албан паспортаар **90** хоног хүртэл / 2021.05.21 |
| **БУСАД ХӨНГӨЛӨЛТ** | | |
| 60. | АНУ | Монгол Улсын иргэдэд 3-10 жилийн хугацаанд олон удаа зорчих виз олгоно. 2001.07.06 |
| 61. | ИБУИНВУ | Монгол Улсын иргэдэд 1 удаа 6 сар хүртэл хугацаагаар суурьших эрхтэй, 6 сараас 10 жилийн хугацаатай олон удаа зорчих виз олгохоор, Их Британийн Дипломат паспорт эзэмшигч иргэд Монгол Улсад 30 хүртэл хоногийн хугацаанд визгүй зорчихоор харилцан тохиролцсон. 2009.06.29 |
| 62. | Канад | Монгол Улсын энгийн паспорттай иргэдэд 10 жил хүртэлх, дипломат болон албан паспорттай иргэдэд 4 жил хүртэлх хугацааны олон удаагийн виз олгоно. 2013.06.04 |
| 63. | Япон | Япон Улсын Засгийн газраас Монгол Улсын иргэдэд 3 хүртэлх жилийн хугацаатай /нэг удаа 15 хүртэлх хоног/ "Богино хугацааны олон удаагийн виз" олгох шийдвэр гаргасан. 2015.08.10 |
| 64. | Швейцарь | Монгол Улсын энгийн паспорттай иргэдэд 3-5 жилийн хугацаатай олон удаа зорчих виз олгоно. 2018.06.16 |
| **Бусад оронд визтэй зорчино** | | |

* Монгол Улс болон Украин Улсын иргэд харилцан зорчиход 1979 онд байгуулсан "Иргэд харилцан визгүй зорчих нөхцөлийг хөнгөвчлөх тухай БНМАУ-ын Засгийн газар, ЗСБНХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр" үйлчлэх бөгөөд иргэд албан ёсны урилга авсан байх шаардлагатай.

## МОНГОЛ УЛСААС ХИЛИЙН ЧАНАДАД СУУГАА ДИПЛОМАТ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРУУД

| № | Хот, ДТГ-ын нэр, Тэргүүний нэр | Холбоо барих хаяг |
|---|---|---|
| | **Элчин сайдын яамд** | |
| 1 | **Абу-Даби**<br>Монгол Улсаас Арабын Нэгдсэн Эмират Улсад суугаа ЭСЯ<br>Элчин сайд Ш.Одонбаатар | Abu Dhabi, Al Bateen, Al Barashi street 6<br>Цахим шуудан: abudhabi@mfa.gov.mn<br>Шуурхай утас: (+971) 28833973, (+971) 562778069 |
| 2 | **Анкара**<br>Монгол Улсаас Бүгд Найрамдах Турк Улсад суугаа ЭСЯ<br>Элчин сайд Г.Мөнхбаяр | Mogolistan Buyukelciligi, A.Fethi Okyar Sokak No.4, Oran Diplomatik Sitesi, Cankaya, 06450 Ankara<br>Утас: 90 (312) 4921027, 90 (312) 4921028<br>Факс: 90 (312) 4921064<br>Цахим шуудан: ankara@mfa.gov.mn<br>Facebook: embmong/<br>Шуурхай утас: +90 3124921028, +905374077814 |
| 3 | **Бангкок**<br>Монгол Улсаас Тайландын Хаант Улсад суугаа ЭСЯ<br>Элчин сайд А.Төмөр | Embassy of Mongolia in the Kingdom of Thailand, Athenee Tower, Unit 604, 6th floor, 63 Wireless road, Lumpini, Pratumwan, Bangkok 10330<br>Утас: +66-(0)-2168-8599<br>Факс: +66-(0)-2168-8599<br>Цахим шуудан: bangkok@mfa.gov.mn<br>Facebook: mongembbkk/<br>Шуурхай утас: +66 818020930, +66 818022942, +66 828500027 |
| 4 | **Берлин**<br>Монгол Улсаас Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад суугаа ЭСЯ<br>Элчин сайд Б.Мандахбилэг | Botschaft der Mongolei Hausvogteiplatz, 14, 10117 Berlin<br>Утас: 49 (30) 47480611, Факс: 49 (30) 47480616<br>Цахим шуудан: berlin@mfa.gov.mn<br>Facebook: BotschaftderMongolei/<br>Шуурхай утас: +49 17629990069 |
| 5 | **Брюссель**<br>Бельгийн Хаант Улсад суугаа ЭСЯ<br>Элчин сайд Л.Болд | Ambassade de Mongolie, Avenue Besme 18, 1190 Forest Bruxelles<br>Утас: 32 (2) 344 6974,<br>Факс: 32 (2) 344 3215<br>Цахим шуудан: brussels@embmongolie.be<br>Facebook: /embmongolie/<br>Шуурхай утас: +32 478785611 |
| 6 | **Бишкек**<br>Бүгд Найрамдах Киргиз Улсад суугаа ЭСЯ<br>Элчин сайд С.Ганхуяг | Embassy of Mongolia in Bishkek, Av, Erkindik 73, city 720040, Republic of Kyrgyz<br>Утас: 996 (312) 660-113,<br>Факс: 996 (312) 660-411<br>Шуурхай утас: +996555666901, +996312660411 |
| 7 | **Будапешт**<br>Монгол Улсаас Унгар Улсад суугаа ЭСЯ<br>Элчин сайд С.Баатаржав | Mongol Nagykovetseg, Bogar Utca 14/c, Budapest 1022, Hungary<br>Утас: +36 3268558, Факс: +36 2125731<br>Цахим шуудан: budapest@mfa.gov.mn<br>Facebook: Embassy-of-Mongolia-in-Budapest/<br>Шуурхай утас: +36 302895151, +36 705850854 |
| 8 | **Бээжин** | No 2, Xiu Shui Bei Jie, Jian Guo Men Wai, Beijing 100600 |

| | | |
|---|---|---|
| | Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсад суугаа ЭСЯ<br>Элчин сайд Т.Бадрал | Утас: 86 (10) 6532 6512, 86 (10) 6532 6513, 86 (10) 6532 1203<br>Факс: 86-10-6532-6216<br>Цахим шуудан: beijing@mfa.gov.mn<br>Шуурхай утас: +86 15210304468, +86 13693382519, +86 18515969636 |
| 9 | **Варшав**<br>Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суугаа ЭСЯ<br>Элчин сайд Б.Дорж | Ambasada Mongolii, ul.Rejtana 15 m.16, 02516 Warszawa, Polska<br>Утас: 48 (22) 849 9391<br>Факс: 48 (22) 848 2063<br>Цахим шуудан: warsaw@mfa.gov.mn<br>Facebook: ESYWAW/<br>Шуурхай утас: +48 538286500 |
| 10 | **Вашингтон**<br>Монгол Улсаас Америкийн Нэгдсэн Улсад суугаа ЭСЯ<br>Элчин сайд Ө.Батбаяр | Embassy of Mongolia, 2833 M Street, NW Washington DC 20007<br>Утас: 1 (202) 333 7117, Факс: 1 (202) 298 9227<br>Цахим шуудан: washington@mfa.gov.mn, monconsul@mongolianembassy.us<br>Facebook: MongoliaDC/<br>Шуурхай утас: +1 2028189020,+1 2022886002 |
| 11 | **Вена**<br>Монгол Улсаас Бүгд Найрамдах Австри Улсад суугаа ЭСЯ<br>Элчин сайд М.Цэнгэг | Botschaft der Mongolei, Fasangartengasse 45, 1130 Vienna, Austria<br>Утас: 43 (1) 5352807-0, Факс: 43 (1) 5352807-20<br>Цахим шуудан: vienna@mfa.gov.mn<br>Facebook: MongolianEmbAustria/<br>Шуурхай утас: +43 6601893985 |
| 12 | **Вьентьян**<br>Монгол Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад суугаа ЭСЯ<br>Элчин сайд Ж.Бямбасүрэн | Embassy of Mongolia in the Lao People's Democratic Republic, Q.Wat Nak Km.3 P.O.Box 370, Vientiane<br>Утас: 856 (21) 315220, Факс: 856 (21) 315221<br>Цахим шуудан: vientiane@mfa.gov.mn<br>Facebook: profile.php?id=100017019253721/ |
| 13 | **Гавана**<br>Монгол Улсаас Бүгд Найрамдах Куба Улсад суугаа ЭСЯ<br>Элчин сайд Ш.Батцэцэг | Embajada de Mongolia, Calle 66 No.505, esquina a 5ta.A, Miramar, La Habana<br>Утас: 53 (7) 2042763, Факс: 53 (7) 2040639<br>Цахим шуудан: havana@mfa.gov.mn<br>Facebook: embajadademongolia.monemb.1/<br>Шуурхай утас: +53 55013982 |
| 14 | **Дели**<br>Монгол Улсаас Бүгд Найрамдах Энэтхэг Улсад суугаа ЭСЯ<br>Элчин сайд Д.Ганболд | Embassy of Mongolia in the Republic of India, 34, Archbishop Macarios Marg, New Delhi 110003<br>Утас: 91 (11) 2461 7989, Факс: 91 (11) 2463 3240<br>Цахим шуудан: delhi@mfa.gov.mn, mongoliadelhi@gmail.com<br>Facebook: Embassy-of-Mongolia-in-New-Delhi-100840858262123/ |
| 15 | **Каир**<br>Монгол Улсаас Арабын Бүгд Найрамдах Египет Улсад суугаа ЭСЯ<br>Элчин сайд Э.Булган | Embassy of Mongolia in the Arab Republic of Egypt, No.14, str 152, MAADI, Cairo<br>Утас: 20 (2) 235 86012, Факс: 20 (2) 235 91670<br>Цахим шуудан: cairo@mfa.gov.mn<br>Facebook: Embassy-of-Mongolia-Cairo-1618980501695605/<br>Шуурхай утас: +20 0112-0762664 |

| | | |
|---|---|---|
| 16 | **Канберра**<br>Монгол Улсаас Австралийн Холбооны Улсад суугаа ЭСЯ<br>Элчин сайд Д.Даваасүрэн | Embassy of Mongolia in the Commonwealth of Australia, 23 Culgoa circuit, O'Malley, Canberra ACT 2606<br>Утас: 61-2-628 629 47, Факс: 61-2-62866381<br>Цахим шуудан: canberra@mfa.gov.mn<br>Facebook: MongolianEmbassyAU/<br>Шуурхай утас: +61 0423058032 |
| 17 | **Кувейт**<br>Монгол Улсаас Кувейт Улсад суугаа ЭСЯ<br>Элчин сайд З.Чинтүшиг | Embassy of Mongolia to the State of Kuwait, Kuwait, Salwa area, Moutaz Street, villa 35<br>Утас: +965 25640208 / 25646020 / 25642262<br>Факс: +965 25648030<br>Цахим шуудан: kuwait@mfa.gov.mn<br>Facebook: Embassy-of-Mongolia/<br>Шуурхай утас: +965 99064541 |
| 18 | **Лондон**<br>Монгол Улсаас Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсад суугаа ЭСЯ<br>Элчин сайд Б.Энхсух | Embassy of Mongolia in the United Kingdom, 7-8 Kensington Court, London, W8 5DL<br>Утас: 44 (207) 937 0150, 7252<br>Факс: 44 (207) 937 1117<br>Цахим шуудан: london@mfa.gov.mn<br>Facebook: Embassy-of-Mongolia-in-the-UK/<br>Шуурхай утас: +44 7874916606 |
| 19 | **Москва**<br>Монгол Улсаас Оросын Холбооны Улсад суугаа ЭСЯ<br>Элчин сайд Ө.Энхтүвшин | Посольство Монголии в РФ, Борисоглебский пер.11, Москва, РФ 115127<br>Утас: 7-495-690-67-92<br>7-495-691-46-36 (Офис менежер)<br>7 (495) 695 43 70 (Элчин зөвлөх), 7 (495) 690 02 45 (Ёслол)<br>Факс: 7 (495) 691 46 36, Факс: 7 (499) 241 15 57, 7 (499) 252 78 67<br>Цахим шуудан: moscow@mfa.gov.mn,<br>Consulate: mongolconsul@gmail.com<br>Facebook: embasmongru/<br>Шуурхай утас: +7 4992411548, +7 4956906792, +7 9162133247 |
| 20 | **Минск**<br>Бүгд Найрамдах Беларусь Улсад суугаа ЭСЯ<br>Элчин сайд Б.Баярсайхан | пр. Победителей 104, оф. 210, г. Минск, 220062, Республика Беларусь<br>Утас: +(375) 17 379 30 99,; Факс: (375) 17 23 0063<br>Цахим шуудан: minsk@mfa.gov.mn<br>Шуурхай утас: +375 29 695 97 99 |
| 21 | **Нурсултан**<br>Монгол Улсаас Бүгд Найрамдах Казахстан Улсад суугаа ЭСЯ<br>Элчин сайд Д.Баярхүү | Посольство Монголии в Республике Казахстан, улица Аскар Токпанова 35, 010010 Нур-Султан<br>Утас: +7 7172 266783, +7 7172 266773<br>Факс: +7 7172 264818<br>Цахим шуудан: astana@mfa.gov.mn<br>Facebook: mongolianembassykz/<br>Шуурхай утас: +7 708 717 3141, +7 717 226 4838, +7 717 226 4858, +7 717 226 7682 |
| 22 | **Оттава**<br>Монгол Улсаас Канад Улсад суугаа ЭСЯ<br>Элчин сайд Я.Ариунболд | 132 Stanley Avenue, ON, Canada K1M 1N9<br>Утас: (613) 569 3830, Факс: (613) 569 3916<br>Цахим шуудан: ottawa@mfa.gov.mn<br>Facebook: MongoliaCanada/<br>Шуурхай утас: +1 3439988806 |

| | | |
|---|---|---|
| 23 | **Парис**<br>Монгол Улсаас Бүгд Найрамдах Франц Улсад суугаа ЭСЯ<br>Элчин сайд У.Нямхүү | Ambassade de Mongolie, 5, Avenue Robert Schuman, 92100 Boulogne-Billancourt<br>Утас: 33 (1) 46052812, 33 (1) 4605 23 18 (Консул)<br>Факс: 33 (1) 46053016<br>Цахим шуудан: paris@mfa.gov.mn<br>Facebook: ambassademongolie/<br>Шуурхай утас: +33 626082898 |
| 24 | **Пхеньян**<br>Монгол Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсад суугаа ЭСЯ<br>Элчин сайд Л.Эрдэнэдавaa | Embassy of Mongolia in the DPRK, Munsu dong-19, Taedonggang District, Pyongyang<br>Утас: 850 (2) 381 7321, Факс: 850 (2) 381 7616<br>Цахим шуудан: pyongyang@mfa.gov.mn |
| 25 | **Прага**<br>Монгол Улсаас Бүгд Найрамдах Чех Улсад суугаа ЭСЯ<br>Элчин сайд Д.Гансух | Velvyslanectvi Mongolska, Na Marne 5, Praha 6, 160 00 Ceska Republika<br>Утас: + 420 214 311 198, , Факс:420 (2) 24314827<br>Цахим шуудан: prague@mfa.gov.mn<br>Facebook: Embassy-of-Mongolia<br>Шуурхай утас: +420 739 015 383, +420 775 874 222 |
| 26 | **Ром**<br>Монгол Улсаас Бүгд Найрамдах Итали Улсад суугаа ЭСЯ<br>Элчин сайд Ц.Нарантунгалаг | Embassy of Mongolia to the Italian Republic, Via Vincenzo Bellini 4, 00198 Rome<br>Утас: 39 (06) 8540536<br>Факс: 39 (06) 8540536<br>Цахим шуудан: rome@mfa.gov.mn<br>Facebook: MongolianEmbassyItaly/<br>Шуурхай утас: +39 328 4688607 |
| 27 | **Софи**<br>Монгол Улсаас Бүгд Найрамдах Болгар Улсад суугаа ЭСЯ<br>Элчин сайд Л.Саянаа | Embassy of Mongolia in the Republic of Bulgaria, 52 Frederic Joliot Curie, Sofia -1113<br>Утас: +359 2 865 90 12<br>Факс: +359 2 963 07 45<br>Цахим шуудан: sofia@mfa.gov.mn, mongemb@gmail.com<br>Facebook: mongembsofia/<br>Шуурхай утас: +359 886764875, +359 886775269 |
| 28 | **Сөүл**<br>Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсд суугаа ЭСЯ<br>Элчин сайд Э.Сарантогос | Embassy of Mongolia in the Republic of Korea, 95, Dokseodang-ro, Yongsan-gu, Seoul 140-885<br>Утас: 82 (2) 798 3464, 82 (2) 798 1950<br>Факс: 82 (2) 794 7605 (ЭСЯ)<br>82 (2) 798 3465 (Консулын газар)<br>Цахим шуудан: seoul@mfa.gov.mn<br>Facebook: embassyofmongolia/<br>Шуурхай утас: +82 01082053464, +82 01027233464 |
| 29 | **Стокхолм**<br>Монгол Улсаас Шведийн Хаант Улсад суугаа ЭСЯ<br>Элчин сайд Т.Жанабазар | Embassy of Mongolia in the Kingdom of Sweden, Svardvagen 25B, 182 33 Danderyd Stockholm<br>Утас: 46 (08) 7531135, 46 (08) 7531136<br>Факс: 46 (08) 7531138<br>Цахим шуудан: stockholm@mfa.gov.mn<br>Facebook: embassyofmongolia.sweden/<br>Шуурхай утас: +46 0733995557 |
| 30 | **Сингапур**<br>Монгол Улсаас Бүгд Найрамдах Сингапур Улсад суугаа ЭСЯ | Embassy of Mongolia in the Republic of Singapore, 600 North Bridge Road, #24-08 Parkview Square, Singapore188778 |

| | | |
|---|---|---|
| | Элчин сайд С.Энхбаяр | Утас: 65 63480745<br>Факс: 65 63481753<br>Цахим шуудан: singapore@mfa.gov.mn<br>Facebook: EmbassyOfMongoliaInSingapore/<br>Шуурхай утас: +65 83534563 |
| 31 | **Токио**<br>Монгол Улсаас Япон Улсад суугаа ЭСЯ<br>Элчин сайд Д.Батжаргал | Embassy of Mongolia in Japan, 21-4 Kamiyama-Cho, Shibuya- Ku, Tokyo 150-0047<br>Утас: 81 (3) 3469-2088<br>81 (3) 3469 2195, 81 (3) 3469 2179 (Консулын газар)<br>81 (3) 3469 2162 (Ёслол), 9868-2299 (гар утас)<br>Факс: 81 (3) 3469 2216<br>Цахим шуудан: tokyo@mfa.gov.mn<br>Facebook: MongolEmb<br>Шуурхай утас: +81 9033191397 |
| 32 | **Ханой**<br>Монгол Улсаас Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсад суугаа ЭСЯ<br>Элчин сайд Ж.Сэрээжав | Embassy of Mongolia to Socialist Republic of Vietnam Villa No 6/44 Van Bao Street, Van Phuc Diplomatic Quarter, Ba Dinh, Hanoi, Vietnam<br>Утас: 84 (24) 384 53009<br>Факс: 84 (24) 384 54954<br>Цахим шуудан: hanoi@mfa.gov.mn<br>Facebook: MonEmbHanoi/<br>Шуурхай утас: +84 936050458, +84 901757164, +84 02438453009 |
| **Байнгын төлөөлөгчийн газар** | | |
| 33 | **Женев**<br>Швейцарийн Холбооны Улс Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суугаа Байнгын Төлөөлөгчийн Газар<br>Элчин сайд Л.Пүрэвсүрэн | Mission permanente de la Mongolie, 4 Chemin des Mollies, 1293 Bellevue Geneve Suisse<br>Утас: 41 0 (22) 7741974, 9868 0157 (гар утас)<br>Факс:41 0 (22) 7743201<br>Цахим шуудан: geneva@mfa.gov.mn<br>Facebook: MongolianEmbassyGeneva/<br>Шуурхай утас: +41 782001777 |
| 34 | **Нью Йорк**<br>Америкийн Нэгдсэн Улс Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суугаа Байнгын Төлөөлөгчийн Газар<br>Элчин сайд В.Энхболд | Permanent Mission of Mongolia to the UN, 6 East 77 th Street, New York, N.Y.10075-1704 USA<br>Утас: 1 (212) 8619460, Факс:1 (212) 8619464<br>Цахим шуудан: newyork@mfa.gov.mn<br>Facebook: profile.php?id=100014159971870<br>Шуурхай утас: +1 3472492591 |
| **Ерөнхий консулын газар, Консулын газар** | | |
| 35 | **Истанбул**<br>Бүгд Найрамдах Турк Улс Истанбул дахь Ерөнхий Консулын газар<br>Ерөнхий консул Ш.Хишигсүрэн | Consulate General of Mongolia in Istanbul, Levent Mahallesi, Levent Caddesi, Güvercin sokak, No: 37, BEŞİKTAŞ/ İSTANBUL/ TURKEY<br>Утас: 90 (212) 662 6162 141<br>Цахим шуудан: istanbul@mfa.gov.mn<br>Facebook: ekgistanbul<br>Шуурхай утас: +90 5513970531, +90 5078253510, +90 5435939079 |
| 36 | **Сан Франциско**<br>Америкийн Нэгдсэн Улс Сан Франциско дахь Ерөнхий Консулын газар | Consulate General of Mongolia in San Francisco, Suite 200, Merchants Exchange Building, 465 California St.San Francisco, CA 94104, USA<br>Утас: 1 (415) 622 4000 |

| | | |
|---|---|---|
| | Ерөнхий консул Б.Ургамалцэцэг | Факс: 1 (415) 622 3000<br>Цахим шуудан: sanfrancisco@mfa.gov.mn<br>Facebook: mongolconsulsf/<br>Шуурхай утас: +1 415 215 2487 |
| 37 | **Осака**<br>Япон улс<br>Осака хот дахь Ерөнхий Консулын Газар<br>Ерөнхий консул Л.Элдэв-Очир | Consulate General of Mongolia in Osaka, 3f Estate Bakurochiyou BLDG<br>1-4-10 Bakuromachi,Chuo-ku, Osaka City Japan 541-0059<br>Утас : 81 (6) 4963-2572, Факс: 81 (6) 4963-2574<br>Цахим шуудан: osaka@mfa.gov.mn<br>Facebook: ConsulateGeneralOfMongoliaInOsaka/<br>Шуурхай утас: +81 649632572 |
| 38 | **Кызыл**<br>Оросын Холбооны Улс<br>Кызыл дахь Ерөнхий Консулын газар<br>Ерөнхий консул Ч.Ганболд | Генеральное Консульство Монголии,<br>Ул.Интернациональная 9, Кызыль РФ 667000<br>Утас: 7 (39422) 20430, Факс: 7 (39422) 20445<br>Цахим шуудан: kyzyl@mfa.gov.mn<br>Шуурхай утас: +7 3942220445, +976 78000730 |
| 39 | **Улаан-Үд**<br>Оросын Холбооны Улс<br>Улаан Үд дахь Ерөнхий Консулын газар<br>Ерөнхий консул Д.Нямцэрэн | Генеральное Консульство Монголии, Ул.Профсоюзная 6, Улан-Удэ, РФ 670000<br>Утас, Факс: 7 (3012) 215275 (Консул), 7 (3012) 210507<br>Утас, Факс: 7 (3012) 220139 (Ерөнхий консулын нарийн бичиг)<br>Утас: 7 (3012) 220499<br>Цахим шуудан: ulan-ude@mfa.gov.mn<br>Facebook: Улаан-Үд-дэх-Ерөнхий-Консулын-Газар<br>Шуурхай утас: +7 (3012)220499, +7 9516224225, +7 9025337213 |
| 40 | **Эрхүү**<br>Оросын Холбооны Улс<br>Эрхүү дахь Ерөнхий Консулын газар<br>Ерөнхий консул Ж.Энхжаргал | Генеральное Консульство Монголии, Ул.Лапина 11, Иркутск, РФ 664003<br>Утас: +7 914 012 6242 (Консул)<br>Факс: 7 (3952) 342143<br>Цахим шуудан: irkutsk@mfa.gov.mn<br>Facebook: generalconsulateirkutsk/<br>Шуурхай утас: +7 914 012 6242, +7 3952 342295, +7 914 895 0528 |
| 41 | **Хөх Хот**<br>Бүгд Найрамдах Хятад Ард Улс<br>Хөх Хот дахь Ерөнхий Консулын газар<br>Консул С.Батхуяг | Zhongguo Huhe Haote, Xinchenqu Wulanxiaoqu 5 hao Lou Menguguo Zhonglinshiguan<br>PRC<br>Утас: 86 (471) 4902531, 86 (471) 4902262<br>Факс: 86 (471) 4902531, 86 (471) 4303250<br>Цахим шуудан: huhhot@mfa.gov.mn<br>Шуурхай утас: +86 15754936989, +86 04714902262 |
| 42 | **Хонконг**<br>БНХАУ-ЫН ЗЗОБ ХОНКОНГ<br>Хонконг дахь Ерөнхий Консулын газар<br>Ерөнхий консул Г.Жаргалсайхан | Consulate General of Mongolia in Hong Kong and Macao Special Administrative Regions of the People`s Republic of China, Unit 1206, Tower 1, Lippo Centre, 89 Queensway, Admiralty, Hong Kong<br>Утас: 852 25222400, Факс: 852 25222405<br>Цахим шуудан: hongkong@mfa.gov.mn<br>Facebook: ConsulateGeneralofMongoliaHK/<br>Шуурхай утас: +852 25222400, +852 93057096 |
| 43 | **Шанхай** | Consulate of Mongolia in Shanghai, 1428. Podong South |

| | | |
|---|---|---|
| | Бүгд Найрамдах Хятад Ард Улс<br>Шанхай хот дахь Ерөнхий консулын газар<br>Ерөнхий консул Ё. Нямжав | road. Shanghai<br>Утас: 21+ 68473255, Факс: 21+ 68473206<br>Цахим шуудан: shanghai@mfa.gov.mn<br>Шуурхай утас: +86 13162982707, +86 13162982596, +86 2168473255 |
| 44 | **Эрээн**<br>Бүгд Найрамдах Хятад Ард Улс<br>Эрээн дахь Консулын газар<br>Консул Т.Мөнхгэрэл | Consulate of Mongolia in Erlian, No.1206, Youyi Beilu Erlianhaote, Inner Mongolia, PRC 011100<br>Утас: 976 92269000<br>Факс: 86 (479) 7589201<br>Цахим шуудан: ereen@mfa.gov.mn<br>Шуурхай утас: +86 15647964334 |
| 45 | **Пусан**<br>Бүгд Найрамдах Солонгос Улс<br>Пусан дахь Консулын газар<br>Консул Ц.Өнөрзаяа | Consulate of Mongolia in Busan 11, Haeun-daero 774beon-gil, Haeundae-gu, Busan, 48104, Republic of Korea<br>Утас: 051 (465) 9996, Факс: 051 (465) 9997<br>Цахим шуудан: busan@mfa.gov.mn<br>Facebook: Consulate-of-Mongolia-in-Busan/<br>Шуурхай утас: +82 010 4966 7103 |
| 46 | **Чикаго**<br>Америкийн Нэгдсэн Улс<br>Чикаго хот дахь Консулын газар<br>Консул Т.Батцэцэг | Unit 405, 1111 Plaza Dr, Schaumburg, IL 60173 Утас: +312-300-2300<br>Факс:+312-847-0144<br>Цахим шуудан: chicago@mfa.gov.mn |
| 47 | **Манжуур**<br>Бүгд Найрамдах Хятад Ард Улс<br>Манжуур дахь Консулын газар<br>Консул Я.Ганбаатар | Manzhouli city, Shangdu guoji no 5, house 11, People's Republic of China<br>Утас:86 (0470) 6236716<br>Факс: 86 (0470) 6236716<br>Email: manjuur@mfa.gov.mn |
| 48 | **Алматы**<br>Бүгд Найрамдах Казахстан Улс<br>Алматы хот дахь Консулын төлөөлөгчийн газар<br>Консул Ч.Баярмагнай | Алматы хот, Бостандык дүүрэг, Мусабаев гудамж, 1<br>Утас: +7 /727/ 247 25 35<br>Факс +7 /727/ 247 25 36<br>Email: almaty2@mfa.gov.mn<br>Facebook: mongolianconsulateinalmaty/<br>Шуурхай утас: +7 7051395535 |
| **Худалдаа, Эдийн засгийн төлөөлөгчийн газар** | | |
| 49 | **Тайбэй**<br>Тайвань<br>Улаанбаатар хотын Худалдаа, Эдийн засгийн Төлөөлөгчийн газар<br>Төлөөлөгчийн газрын тэргүүн Л.Золзаяа | Ulaanbaatar Trade and Economic Representative office in Taipei, Suite 1112, TWTC International Building 333 Keelung Rd, Sec.1, Taiwan<br>Утас: 886 (02) 2722 9740<br>Факс: 886 (02) 2722 9745<br>Цахим шуудан: ubtrade.taipei@outlook.com<br>Facebook: ubtero.ub<br>Шуурхай утас: +886 2722-9740, +886 0900676733 |